



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 16

Эрдэнэт хот

Г Тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188, 2018 оны А/06 дугаар тушаал, "Нийцлийн аудитын түр журам"-ын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Орхон аймагт 2017 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөрчлийн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аудитын тайланг Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг төлүүлэх, зөрчлийн албан шаардлагыг арилгуулах, өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч үр дүнг 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч /А.Түвшинжаргал/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга /Х.Эрдэнэбат/ нарт зөвлөсүгэй.
4. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, аудитор /Д.Цогбадрах/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

070032



ОАГ
ОРХОН АУДИТЫН ГАЗАР

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ОРХОН АЙМАГТ 2017 ОНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ”

ОРА-2018-01-НА



Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн дүнд ажилгүйчүүдийн тоо буурч, иргэдийн амьдрал хэрхэн дээшилж байгааг бодитой тодорхойлоогүй, дотоодын хяналт шалгалтыг хийхдээ үр дүнг тооцож цаашдын зорилго зорилтыг тодорхойлоход чиглүүлэх шаардлагатай байна.

Орхон аймаг
2018 он

Агуулга

Аудитын тайланг бэлтгэсэн:	Ц.Нармандах	Товчилсон үгсийн жагсаалт	2
Орхон аймаг дахь Төрийн аудитын газар		Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Дарга, тэргүүлэх аудитор :	Б.Эрдэнэ	Бүлэг I. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 5/02 дугаар тогтоолоос батлагдсан “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /Нэг өрх-нэг ажлы байр/ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллажээ.	
		1.1. Аймгаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийг хөгжлийн бодлого төлөвлөлтий тухай хууль журманд заасны дагуу зохих байгууллагад хүргүүлж зөвшөөрөл а эрх бүхий этгээдээр батлуулсан байна.....	5
		1.2. Хөтөлбөрийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан байна.....	6
		1.3. “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн хүрээнд 95 иргэ байнгын ажлын байраар, 24 иргэн түр ажлын байраар хангагдсан байна.....	7
		1.4. Хэрэгжиж буй хөтөлбөрийн үйл ажиллагаанд тавих хяналт хийгдээг байна.....	8
Аудитын менежер:	Д.Цогбадрах	Бүлэг II. ХЭДТХ-нд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилахаар заас дагуу орон нутгаас 100,0 сая төгрөг хуваарилсан байна. Харин хөгжлий бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг Монгол улс Засгийн газрын тогтоолд заасны дагуу төлөвлөж төвлөрүүлээгүй нь 59, сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжийг алдсан байна.	
Аудитор	3.Энх-Амгалан	2.1. Сангийн эх үүсвэрийг хууль, тогтоомжтой уялдуулан төлөвлөөгүй, ор нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилсан ч ХЭДС-ийн дансаар бус Хөдөлмө халамжийн үйлчилгээний газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуул зарцуулсан байна.....	9
Гэрээт ажилтан		2.2. Сангийн орлогын бүрдүүлэлтийг бүрэн төвлөрүүлээгүй, төсөл хөтөлбөр ХЭДС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.....	10
2018 оны 04 дүгээр сар		Бүлэг III. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан хэдий ч хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн дүнд иргэдийн амьдрал дээшилж байгаа нь тодорхойгүй, судалгаа бүрэн хийгдээгүй байна.	
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж, тодруулах, лавлах зүйл байвал 70355805 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.		3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, журмын даг зарцуулжээ.....	12
		3.2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн дүнд ажилгүйчүүди тоо буурч иргэдийн амьдрал дээшилж байгаа эсэх нь тодорхойгүй, судалг бүрэн хийгдээгүй байна.....	26
Аудитын тайланг УАГ-ын веб сайтаас үзнэ үү. www.audit.mn		Бүлэг IV. Дотоодын хяналт хийхдээ шалгалтын зорилго, үр дүнг оновчтой тодорхойлоогүй, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр нь ямар үр дүнд хүрсэн, цаашид ямар арга хэмжээг авч ажиллах, үр дүнг тооцож, цаашдын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдээгүй байна.	
Хаяг: Орхон аймаг дахь төрийн аудитын газар		4.1. Сангийн хөрөнгийн зарцуулалтанд дотоод хяналт хийж ажилласан хяналтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус байна.....	27
		4.2. Сангийн үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө төвлөрүүл зарцуулж байгаа боловч түүний зарцуулалт, үр дүнг тооцож, цаашдын зорилт хэрэгжүүлэхэд дотоод хяналтын ажлыг чиглүүлээгүй байна.....	28
Баян-Өндөр сум,		Дүгнэлт	29
Хүрэнбулаг баг,		Зөвлөмж	29
Нутгийн удирдлагын ордон		Мэдэгдэл	31
		Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал.....	32
		Саналд өгсөн тайлбар.....	38
		Тайлан баталгаажуулсан тушаал.....	40

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
ХЭДТХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУИС	Монгол улсын их сургууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХЭСЗ	Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл
ХЭАЗ	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл
ЗХХ	Захиргаа хяналтын хэлтэс
АБДХ	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
ХБИАБДХ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:

Аудит хийх үндэслэл: Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар баталсан “аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, сэдэв”-ийн дагуу Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 2017 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийнэ. Үүнд:

1. Аймгаас хэрэгжүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн үр дүнг тооцсон эсэх;
2. ХЭДСангийн орлогыг хууль, журамд зааснаар бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх;
3. ХЭДСангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зарцуулсан эсэх;
4. ХЭДСангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх;

Аудитын хамрах хүрээ: Аудитыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон Баян-өндөр, Жаргалант сумдын хөдөлмөр, халамж үйлчилгээний ажлын баримтад тулгуурлан 2017 оны ХЭДСанд улс, орон нутгийн төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг, бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээ, бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй: Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглана.

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1-р хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “ Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”

- Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг батлах тухай”
 - “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/18 тоот тушаал
 - “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/26 тоот тушаал
 - Аймгийн ИТХурал, ЗД-аас гаргасан тогтоол, шийдвэрүүд.

Гүйцэтгэсэн хугацаа: Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ хэрэгжүүлж, нийцлийн аудитын баг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр эхэлж, 04 дугаар сарын 20-ны өдөр дуусгаж, аудитын тайланг Аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Тэргүүлэх аудиторроор баталгаажууллаа.

Үндсэн мэдээлэл: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/17 тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны төсвийн хуваарийг 1384.4 сая төгрөгөөр баталсан. Үүнээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд 845.5 сая төгрөг, жижиг зээлийн арга хэмжээнд 300.0 сая төгрөг зарцуулжээ.

2017 оны Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан болох LMIS программ-д 1229 идэвхтэй ажил хайгч иргэн бүртгэлтэй байгаагийн 705 нь буюу 57.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж, аймгийн хэмжээнд энэ оны байдлаар сул чөлөөтэй ажлын байранд 1170 иргэн ажилд орсон байна. Нийт ажилд орсон иргэдийн 94.2 хувь нь буюу 1103 иргэн байнгын ажлын байртай болжээ.

Орхон аймгийн хэмжээнд нийт 12 улсын 545 гадаадын иргэн ажиллаж, амьдарч байна.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ ганаарчилсан хэлбэрээр нийт 555 иргэнд хөдөлмөр эрхлэлт, ажилд зуучлах үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна. Үүний 386 нь эмэгтэйчүүд байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас эрх авсан Орхон МСҮТ болон “Мөнх-Оюуны холбоос” сургалтын байгууллагуудтай хамтран ЕБС, МСҮТ-ийн суралцагсад, цэргээс халагдсан, ажил хайгч, хорих ангид хүмүүжиж буй, хөгжлийн бэрхшээлтэй нийт 825 иргэнийг хамруулж ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг явуулжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг шинэчлэн “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”, “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, нийт 6 хөтөлбөр баталсан байна. Үүнээс 5 хөтөлбөрийн арга хэмжээнд иргэдэд хүүгүй, барьцаагүй итгэлцэлийн үндсэн дээр зээл олгохоор тусгагдсан байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Аймгаас хэрэгжүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн үр дүнг тооцсон эсэх.

Бүлэг 1

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 5/02 дугаар тогтоолоор батлагдсан “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /Нэг өрх-нэг ажлын байр/ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллажээ.

1.1 Аймгаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийг хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль журманд заасны дагуу зохих байгууллагад хүргүүлж, зөвшөөрөл авч, эрх бүхий этгээдээр батлуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг шинэчлэн “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”, “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нийт 6 хөтөлбөр баталсан байна. Үүнээс 5 хөтөлбөрийн арга хэмжээнд иргэдэд хүүгүй, барьцаагүй итгэлцэлийн үндсэн дээр зээл олгохоор заажээ.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/07 тоот захирамжаар “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /Нэг өрх-нэг ажлын байр/ дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, Орхон аймгийн хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй иргэдээс судалгаа авч, хэлэлцүүлэг зохион байгуулж, эрэлт хэрэгцээг тодорхойлон иргэдээс гаргасан саналыг тусгаж хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 5/02 дугаар тогтоолоор хөтөлбөрийг баталжээ.

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /Нэг өрх-нэг ажлын байр/ дэд хөтөлбөрийг боловсруулах үндэслэл нь Орхон аймгийн 101.8 мянган хүн амын 64.5 хувь хөдөлмөрийн насных бөгөөд үүний 50.4 хувь нь хөдөлмөр эрхэлж, 22000 гаруй иргэн ажилгүй, ажилгүй иргэдийг судлахад өрхийн гишүүд нь огт ажил эрхэлдэггүй 1147 өрхийн 2314 иргэн байгаа нь нөлөөлсөн байна.

Хөтөлбөрийн зорилго нь өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг тодорхойлж тэднийг хөдөлмөрт бэлтгэх, мэргэжлийн үр чадвар олгох, ажилд зуучлах, ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэхэд оршино гэж заажээ.

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийг боловсруулахдаа холбогдох төрийн байгууллагуудын төлөөллийг сайн оролцуулсан боловч төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулаагүй, тухайн асуудалтай холбоотой мэдээллийг бусад хүчин төгөлдөр бодлогын баримт бичиг судалгаа мэдээллээс иш татсан тохиолдолд бодлогын баримт бичиг болон судалгаа мэдээллийн эх сурвалжийг заасан зүйл байхгүй боловч эрх зүйн жагсаалтыг гаргаж хавсаргасан байна.

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийг боловсруулахдаа хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулахад 288 иргэн оролцож, 21 иргэн саналаа хэлж, 58 иргэнээс бичгээр санал авчээ.

Эдийн засаг нийгэм эсвэл тодорхой зорилтот бүлэгт урт дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай ажил үйлчилгээтэй холбоотой асуудлын эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө их гэж үзсэн судалгаа, нөлөөллийн урьдчилсан үнэлгээг гүйцэтгэж, төсөлд тусгаагүй байна.

1.2. Хөтөлбөрийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд 300.0 сая төгрөг төвлөрүүлж “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /Нэг өрх-нэг ажлын байр/ дэд хөтөлбөрийн санхүүжилтэнд 300.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаанд 60.0 сая төгрөг, итгэлийн зээлд 200.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлийн гуравдугаар хуралдаанаар – “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалтай танилцан, нэмэлт хуваарилсан 72.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг хэлбэрээр олгох, өрхөөрөө үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулж 100.0 сая төгрөг, тоног төхөөрөмжид 100.0 сая төгрөгийг үйлдвэрлэл явуулах ажлын байрны дэмжлэг үзүүлэх хэлбэрээр хуваарилах саналыг Засаг даргад уламжлахаар шийдвэрлэсэн байна.

Орон нутгийн төсвөөс 100.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж судалгааны ажилд 6.0 сая төгрөг, сургалтанд 6.0 сая төгрөг, эргүүл хамгааллын ажилд 13.0 сая төгрөг, урамшуулах зардалд 3.0 сая төгрөг, зээлийн санхүүжилтэд 72.0 сая төгрөг, нийт 100.0 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр эргүүл хамгааллын ажилд 12.9 сая төгрөг, урамшуулал зардалд 3.0 сая төгрөг, зээлийн санхүүжилтэд 72.0 сая төгрөг, судалгааны ажилд 6.0 сая төгрөг, сургалтанд 6.0 сая төгрөг, нийт 99.9 сая төгрөг зарцуулжээ.

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох ажлын хүрээнд 2017 оны 11 дүгээр сарын 17-21 ны хооронд зээлийн хүсэлт хүлээн авч 44 иргэн хүсэлт ирүүлсэнийг 4 ажлын хэсэг гарган ажиллуулж үнэлгээ хийн Баян-Өндөр сумын 26 иргэнд 2 жилийн хугацаатай 72.0 сая төгрөгийн хүүгүй зээлийг 2017 оны 12 дугаар сард олгосон ба зээл авсан иргэд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

- Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл -2 иргэн
- Оёдол, сүлжмэлийн үйлдвэрлэл -11 иргэн
- Бэлэг дурсгал –2 иргэн
- Хоол үйлдвэрлэл, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэл -3 иргэн
- Хуванцар эдлэл үйлдвэрлэл -1 иргэн
- Хэвлэлийн үйл ажиллагаа -1 иргэн
- Төмөр болон модон эдлэл үйлдвэрлэл -4 иргэн
- Авто засварын үйлчилгээ -1 иргэн
- Гоо сайхны үйлчилгээ -1 иргэн



“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрөөс санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн хийсэн бялуу, бэлэг дурсгалын зүйлс.

Аудитын хүрээнд төслийн үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 18 иргэнтэй уулзсан бөгөөд зээлийн санхүүжилтийг 11 иргэн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад, 7 иргэн материал авахад тус тус зарцуулсан дүнтэй байна.

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн 5.4-т “заасан орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн болон бусад орон нутгаас зарлаж байгаа ажлын байрны захиалгад тулгуурлан ажилд зуучлах арга хэмжээг зохион байгуулах” зорилтын хүрээнд:

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн 5.4.8-д “иргэдийн санал, санаачилгад тулгуурлан олон нийтийн эргүүл хамгаалалт, байгаль хамгаалах, нөхөн сэргээх, гэмт хэрэг, осол гэмтлээс сэргийлэх бүлэг ажиллуулах чиглэлээр улирлын чанартай ажлын байраар хангаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулах” гэж заажээ.

Энэ заалтын хүрээнд эргүүл хамгаалалтын ажилд Дэнж багийн 2 иргэн, Наран багийн 1 иргэн, Эрдэнэ багийн 2 иргэн, Баянцагаан багийн 1 иргэн, Булаг багийн 2 иргэн, Говил багийн 1 иргэн, Уртын гол багийн 2 иргэн, Баянбулаг багийн 1 иргэн, Рашаант багийн 1 иргэн, Оюут багийн 1 иргэн, Зэст багийн 1 иргэн, Жаргалант багийн 1 иргэн, Улаантолгой багийн 1 иргэн, нийт 17 иргэн хамрагдаж түр ажлын байраар хангагджээ.

Эргүүл хамгаалалтын ажилд хамрагдсан 17 иргэний цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 12.9 сая төгрөг, урамшууллын зардалд 3.0 сая төгрөг нийт 15.9 сая төгрөг зарцуулсан байна.

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилтнуудын сургалт зохион байгуулахад 0.8 сая төгрөг, “хөгжил бүтээх 18” өдөрлөгт 0.8 сая төгрөг, дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох сургалтанд 0.8 сая төгрөг, “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн өдөрлөг, үзэсгэлэн худалдаанд 2.2 сая төгрөг, “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн ажлын байрыг дэмжих эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээний үнэлгээ хийхэд 1.4 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Мөн “ETV” телевизээр дараах нэвтрүүлгийг 1.2 сая төгрөгөөр хийлгэсэн байна. Үүнд: “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн 1 минут 6 секундын шторк хийлгэж 2017.11.01-2017.12.25-ыг дуустал өдөр бүр 10 удаа, “Эргүүлийн ажилтан” сурвалжлага 21 минут 55 секундын нэвтрүүлэг 4 удаа, “Мэргэжил олгох сургалт” 22 минут 33 секундын нэвтрүүлэг 4 удаа, “Өрхийн үйлдвэрлэл” 25 минутын нэвтрүүлэг 4 удаа тус тус эфирт цацсан байна.

1.3. “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн хүрээнд 95 иргэн байнгын ажлын байраар, 24 иргэн түр ажлын байраар хангагдсан байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон 2017 оны төсвийн хуваарийг хэлэлцүүлсэн. “Хөгжил бүтээх-18” дэд хөтөлбөрүүдийн нээлтийн үйл ажиллагааны хүрээнд “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /Нэг өрх-нэг ажлын байр/ хөтөлбөрийн нээлтийг зохион байгуулжээ.

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн өдөрлөгийн нээлтийн хүрээнд 29 ажил олгогчоос 71 ажлын байранд 105 иргэнийг авах сул чөлөөтэй болон шинэ байрны захиалга ирснээс 65 иргэнийг ажилд зуучлан оруулсан байна. Үүнээс 12 ажил олгогч, 36 иргэнтэй Хөдөлмөр зуучлалын гэрээ буюу “Гурвалсан гэрээ” байгуулжээ.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд 30 иргэний бүртгэл мэдээллийг идэвхижүүлсэн. 3 ажил олгогчоос 5 ажлын байранд 9 иргэнийг ажилд авах захиалга хүлээн авсан. Өдөрлөгийн үеэр нийт 28 ажил олгогч оролцож 300 иргэний анкетыг бүртгэн авч ярилцлага авчээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгож байгаа Капитал, Голомт банк оролцож иргэдэд мэдээлэл хүргэж 10 иргэний зээлийг судлахаар бүрдүүлэх

материалын жагсаалтыг хүргүүлэн, мэргэжил олгох сургалтанд тогооч, оёдолчин, үсчин, гагнуурчин, нярав, цэцэрлэгийн туслах багш зэрэг 6 мэргэжлээр нийт 57 иргэнийг бүртгэн авчээ.

Худалдааны гудамжны үйл ажиллагааг тогтмолжуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор тус гудамжинд ажлын байргүй, өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэдэд зөөврийн павилон байрлуулан худалдаа, үйлчилгээ эрхлэх боломж нээгдсэн ба энэхүү ажлыг эхлүүлэхэд Баян-Өндөр сумаас стандарт, чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан 4 жишиг павилоныг хийлгэж байршуулах ажил хийгдсэн байна.

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” хөтөлбөрийн хүрээнд 95 иргэн байнгын ажлын байраар, 24 иргэн түр ажлын байраар хангагдсан байна. Харин энэ хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийн хүрээнд 21 иргэн байнгын ажлын байраар, 7 иргэн түр ажлын байраар хангагдсан ба нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй 16 иргэн, албан байгууллагад ажилдаг 3 иргэн, сайн дурын даатгуулагч 4 иргэн байна.

1.4. Хэрэгжиж буй хөтөлбөрийн үйл ажиллагаанд тавих хяналт хийгдээгүй байна.

ЭРДЭНЭТЧҮҮД ЭРДЭНЭТЧҮҮДДЭЭ ХАЙРТАЙ дэд хөтөлбөрийн судалгааны зардалд төсөвлөсөн 6.0 сая төгрөгөөс дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангах программыг 3.5 сая төгрөгөөр хийлгэсэн боловч программыг орлогод авч биет бус хөрөнгөөр бүртгээгүй зөрчилд цаашид хууль журмын дагуу бүртгэж байх зөвлөмжийг хүргүүллээ.

Мөн судалгаа авах ажлын багт нэг бүр нь 65.0 мянган төгрөгний үнэтэй 25 ширхэг, нийт 1625.0 мянган төгрөгний принтерийн хорыг “ОЮУ ШАГАЙ” ХХК-аас худалдан авч олгосон ба эдгээр принтерийн хорны зарагдаж байгаа үнийг загвар тус бүрээр нь судалж үзэхэд 35.0 мянган төгрөгний 17 ширхэг хор, 45.0 мянган төгрөгний 1 ширхэг хор, 55.0 мянган төгрөгний 7 ширхэг хор, нийт 1025.0 төгрөгөөр авах боломжтой байсан ба ийм зөрчлийг дахин гаргуулахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

“Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.5-3.7-д заасны дагуу дотоод хяналт шалгалтыг хийж хэрэгжүүлээгүй байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг хууль, журамд зааснаар бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх;

Бүлэг 2

ХЭДТХ-нд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилахаар заасны дагуу орон нутгаас 100,0 сая төгрөг хуваарилсан байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг Монгол улсын Засгийн газрын тогтоолд заасны дагуу төлөвлөж төвлөрүүлээгүй нь 597,1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжийг алдсан байна.

2.1. Сангийн эх үүсвэрийг хууль, тогтоомжтой уялдуулан төлөвлөөгүй, орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилсан ч ХЭДС-ийн дансаар бус Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан нь улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, сангийн хөрөнгийг банкинд хадгалуулсны хүү, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр, бусад эх үүсвэрээс бүрдэнэ гэж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулинд заажээ.

ХЭДС нь 2017 онд улсын төсвөөс 803.5 сая төгрөгийн санхүүжилт өмнөх оны өр барагдуулсан орлогоос 42.8 сая төгрөг нийт 846.3 сая төгрөгөөр санхүүжихээр төлөвлөн гүйцэтгэлээр санхүүжилтэнд 684.8 сая төгрөг, өмнөх оны өр барагдуулсан 42.8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт 15.5 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 111.5 сая төгрөг, өмнөх оны санхүүжилт үлдэгдлээс 6.8 сая төгрөг нийт 861.5 сая төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.3-д “дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байна” гэж заасныг үндэслэн Засаг даргын А/326 тоот захирамжаар “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 100.0 сая төгрөгийг ХЭДС-д хуваарилсан боловч ХЭДС-ийн дансаар бус Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

Монгол улсын Засгийн газрын 2009 оны 01 дүгээр сарын 28-ны 26 тоот тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ”-г 50 хүртэлх ажилтантай бол Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 40 хувиар, 51-ээс дээш ажилтантай бол Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиар сар бүр төлөхөөр тогтоосон тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.

2017 онд Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй нийт 1294 байгууллага байгаагаас төсвийн байгууллага 101, ТӨХК 6, ОНӨХК 1, ОНӨААТҮГ 1, хувийн 1185 байгууллага байгаагийн 1052 ХХК, 12 хоршоо, 48 нөхөрлөл, 47 ТББ, 26 СӨХ байна.

Үүнээс 25-аас дээш ажилтантай буюу хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтыг дагаж мөрдөж ажиллах төсвийн 67 байгууллага, ТӨААН 6, ОНӨААН 1, хувийн 50 байгууллагаас 49 ХХК, 1 хоршоо нийт 124 байгууллага байна. Эдгээрээс хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтыг хэрэгжүүлсэн төрийн 32 байгууллага, хувийн 11 байгууллага нийт 43 байгууллага байна. Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой

хүн ажиллуулаагүйн төлбөр нэхэмжилбэл зохих төсвийн 38, ТӨХК 3, ОНӨХК 1, хувийн 39 ХХК, нийт 81 байгууллага байгаагаас хөдөлмөрийн тухай хуулийн 111.6 “ Аж ахуй нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлнө” гэсэн заалтын дагуу 2017 онд Монголын цахилгаан холбоо ТӨХК 1.2 сая төгрөг, Ачит-Ихт ХХК 10.1 сая төгрөгийн төлбөрөөс тус тус чөлөөлөгджээ.

2.2. Сангийн орлогын бүрдүүлэлтийг бүрэн төвлөрүүлээгүй, төсөл хөтөлбөрийг ХЭДС-ын хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

ХБИ-г ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг авах тухай албан бичгийг хүргүүлсэн боловч үр дүнд хүрээгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолын дагуу тооцоолж үзэхэд 2017 онд 35 ААНБ-аас 423.8 сая төгрөг, 38 төсвийн байгууллагаас 173.3 сая төгрөг, нийт 597.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжийг алдсан байна.

2017 онд ХХҮГ-аас Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд төсвийн 6 байгууллага, 3 ТӨХК, ОНӨХК 1-д нийт 20.2 сая төгрөгийн нэхэмжлэх хүргүүлж 9.8 сая төгрөг, хувийн 12 ХХК-д 32.7 сая төгрөгийн нэхэмжлэх хүргүүлж 5.7 сая төгрөг, нийт 22 байгууллагад 52.5 сая төгрөгийн нэхэмжлэх өгч 15.5 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэхэмжлэл хүргүүлсэн байдал:

Монголын цахилгаан холбоо ТӨХК нь 2015, 2016 онуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг тасралтгүй төлсөн. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 6-д “Аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлнө” гэж заасны дагуу Монголын цахилгаан холбоо ТӨХК нь 2017 онд 1.2 сая төгрөгийн төлбөрөөс чөлөөлөгдсөн байтал 1.1 сая төгрөгийн нэхэмжлэл өгч 0.6 сая төгрөг төвлөрүүлсэн.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1-д “25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна” гэсэн заалтыг мөрдөж ажилласан Жаргалант сургууль, Маргад тамир ХХК, Шим технологиджи ХХК гэсэн 3 байгууллагад 4.6 сая төгрөгийн нэхэмжлэл хүргүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас нийт 22 байгууллагаас 52.5 сая төгрөгийн нэхэмжлэхдээ доорхи 11 байгууллагын нэхэмжилбэл зохих 60.5 сая төгрөг байхад 30.0 сая төгрөг нэхэмжилж 30.5 сая төгрөг дутуу нэхэмжилсэн байна.

/нэхэмжилсэн дүн зөрүүтэй/

Д/д	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Нэхэмжилбэл зохих дүн	Нэхэмжилсэн дүн	Зөрүү дүн
1	Орхон АЗЗА ТӨХК	2,880,000	1,152,000	1,728,000
2	Шүүх	2,880,000	2,304,000	576,000
3	ЭБЦТСүлжээ ТӨХК	11,520,000	2,304,000	9,216,000
4	Эрдэнэт ус ДТС ОНӨХК	8,640,000	5,760,000	2,880,000
5	Медипас ХХК	5,760,000	4,320,000	1,440,000

6	МУИС-ийн Эрдэнэт сургууль	4,320,000	2,880,000	1,440,000
7	Ник ХХК Орхон салбар	7,200,000	4,608,000	2,592,000
8	Номинтав трейд ХХК	4,320,000	2,880,000	1,440,000
9	Оддөл ХХК	2,880,000	1,152,000	1,728,000
10	Эрдсүлж ХХК	7,200,000	1,152,000	6,048,000
11	Эрдэнэт фүүдс ХХК	2,880,000	1,440,000	1,440,000
Нийт		60,480,000	29,952,000	30,528,000

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас нийт 22 байгууллагаас 52.5 сая төгрөгийг нэхэмжлэн 7 байгууллагаас 15.5 сая төгрөгийг санд төвлөрүүлж ажилласан байна.

/Нэхэмжилсэн болон төлөгдсөн дүн/

Д/д	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Нэхэмжилсэн дүн	Төлөгдсөн дүн	Зөрүү дүн
1	Бялзуухай цэцэрлэг	1,152,000		1,152,000
2	Жаргалант сургууль	1,152,000		1,152,000
3	Жаргалант 3-р цэцэрлэг	1,152,000		1,152,000
4	Монголын цахилгаан холбоо ТӨХК Орхон	1,152,000	600,000	552,000
5	Нийгмийн даатгалын хэлтэс	2,880,000		2,880,000
6	Одод цэцэрлэг	1,152,000		1,152,000
7	Шүүх	2,304,000		2,304,000
8	ЭБЦТСүлжээ ТӨХК	2,304,000	2,304,000	-
9	Эрдэнэт ус ДТС ОНӨХК	5,760,000	5,760,000	-
10	Орхон АЗЗА ТӨХК	1,152,000	1,152,000	-
11	Маргад тамир ХХК	1,520,000		1,520,000
12	Медипас ХХК	4,320,000	2,520,000	1,800,000
13	МУИС-ийн Эрдэнэт сургууль	2,880,000	1,752,000	1,128,000
14	Ник ХХК Орхон салбар	4,608,000		4,608,000
15	Номинтав трейд ХХК	2,880,000		2,880,000
16	Оддөл ХХК	1,152,000		1,152,000
17	Ораметалл ХХК	4,320,000		4,320,000
18	Орхон инженеринг менежмент ХХК	2,880,000		2,880,000
19	Орхон эмпати сургууль	2,880,000		2,880,000
20	Шимтехнолоджи	2,304,000		2,304,000
21	Эрдсүлж ХХК	1,152,000		1,152,000
22	Эрдэнэт фүүдс ХХК	1,440,000	1,440,000	-
Нийт		52,496,000	15,528,000	36,968,000

Гэвч нэхэмжлэл хүргүүлээд дутуу төлөгдсөн болон огт төлөгдөөгүй байгууллагуудтай тооцоо нийлсэн болон ямар нэгэн тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

“Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллана” гэсэн ажлын байрны тодорхойлолттой Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэнд боловсруулсан тооцоо, судалгаа байгаагүй нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй, ажлын хариуцлага сул, тооцоо судалгаагүй ажиллаж байна гэж дүгнэхэд хүргэж байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зарцуулсан эсэх;

Бүлэг 3

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан хэдий ч хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн дүнд иргэдийн амьдрал дээшилж байгаа нь тодорхойгүй, судалгаа бүрэн хийгдээгүй байна.

3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулжээ.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2017-2018 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох”, “Ажлын байрыг дэмжих”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх” 6 хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.

Дээрх хөтөлбөрүүд нь тус бүрийн онцлогоосоо хамаараад харилцан адилгүй хэмжээ, хугацаатайгаар иргэдэд зээл олгох, ижил тал нь хүүгүй, 100 хувийн эргэн төлөлттэй байх юм. Уг хөтөлбөрүүд нь зээл олгох төдийгүй мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зэрэг олон талтай арга хэмжээ байна.

2017 оны хөрөнгийн зарцуулалт :

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Хүн /давхардсан тоогоор/	Зарцуулсан мөнгөн дүн
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ	1380	10.2
Ажилд зуучлах	1168	6.3
Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	339	39.2
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2052	432.1
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	144	30.9

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	36	42.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	64	53.3
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	69	28.2
Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр		3.6
Аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал		2.9
Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт		6.4
Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах		0.1
Хөдөлмөрийн салбарын ажилчдын сургалт		2.9
Сурталчилгаа олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах		10.0
Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ		2.0
Гарын авлага хэвлэмэл материал		0.5
2016 оны өглөг барагдуулах		42.8
Нийт	5252	713.7

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд:

Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулахад 170 хүн хамруулж 39.1 сая төгрөг, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх сургалт зохион байгуулахад 168 хүн хамруулж 7.6 сая төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөн, гүйцэтгэлээр мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулахад 171 хүн хамруулж 31.7 сая төгрөг, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх сургалт зохион байгуулахад 168 хүн хамруулж 7.6 сая төгрөг зарцуулжээ.



Гагнуур, гоо заслын мэргэжил олгох сургалтын үйл явц

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 2 дугаар бүлгийн 1.3.1-д "мэргэжлийн сургалтанд ажилгүй болон ажлын байранд зуучлагдах болон хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэнийг, давтан сургалтанд ажил олгогчийн хүсэлтийг үндэслэн ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг тус тус сургана" гэж заасны дагуу, "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ"-г үндэслэн ажилгүй 171 хүнийг 11 мэргэжлээр 31.7 сая төгрөгийн зардалтай сургалтанд хамруулсан байна. Үүнд: засал чимэглэлчин-14, гагнуурчин-15, сантехникч-9, /нэг суралцагчид ногдох сургалтын зардал 240.0 мянган төгрөг/, оёдолчин-25, тогооч-25, сүлжигч-10, /нэг суралцагчид ногдох сургалтын зардал 180.0 мянган төгрөг/, үсчин-20, гоо засалчин-12, гэр ахуйн цахилгаанчин-20, /нэг суралцагчид ногдох сургалтын зардал 160.0 мянган төгрөг/, нярав, худалдагч-12 /нэг суралцагчид ногдох сургалтын зардал 140.0 мянган төгрөг/, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин-9, /нэг суралцагчид ногдох сургалтын зардал 200.0 мянган төгрөг/

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн 3.1.2-д "хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалт явуулах" гэж заасны дагуу "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээнд хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын жишиг хэмжээ 45.0 мянган төгрөг" гэж заасныг үндэслэн ажилгүй 168 иргэнийг 7.6 сая төгрөгийн зардалтай сургалтанд хамруулжээ.

Дээрх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ
Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр						
Мэргэжлийн сургалт	170	39.1	171	31.7	1	7.4
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх	168	7.6	168	7.6	-	0.0
Нийт		46.7		39.2	1	7.4

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд:

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг 68 хүнд олгож 201.0 сая төгрөг, аж ахуй эрхлэх ур чадвар олгох сургалтанд 184 хүн хамруулж 5.5 сая төгрөг, борлуулалтын дэмжлэг үзүүлэхэд 7.2 сая төгрөг, ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөнд 23 хүн хамруулж 11.0 сая төгрөг, ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 12 хүн хамруулж 34.6 сая төгрөг, нийтийг хамарсан ажил зохион байгуулж 180 хүн оролцуулж 164.1 сая төгрөг, бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 70 хүнийг оролцуулж 35.0 сая төгрөг тус тус зарцуулахаар төсөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг 68 хүнд олгож 201.0 сая төгрөг, аж ахуй эрхлэх ур чадвар олгох сургалтанд 126 хүн хамруулж 3.8 сая төгрөг, борлуулалтын дэмжлэг үзүүлэхэд 7.2 сая төгрөг, ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөнд 3 хүн хамруулж 0.5 сая төгрөг, ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 12 хүн хамруулж 32.3 сая төгрөг, нийтийг хамарсан ажил зохион байгуулж 1769 хүн оролцуулж 163.7 сая

төгрөг, бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 72 хүнийг оролцуулж 23.7 сая төгрөг зарцуулжээ.

Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 2 дугаар бүлгийн 2.2.2.1- д " жижиг зээл болон энэхүү хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг авах төсөл ирүүлсэн болон шийдвэрлэгдсэн иргэд түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдаагүй аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийг өөрсдийн хүсэлтэд нь үндэслэн аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулна" гэж заасны дагуу "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох 5 хоногийн сургалтын зардлын жишиг хэмжээ 30.0 мянган төгрөг" гэж заасныг үндэслэн 126 иргэнийг 3.8 сая төгрөгийн зардалаар сургалтанд хамруулсан байна.

Борлуулалтын дэмжлэг: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 2 дугаар бүлгийн 2.3.1-д "Борлуулалтын цэгийг ажиллуулах зардлыг зөвхөн түрээсийн төлбөр болон урсгал зардалд зарцуулна" гэж заасны дагуу "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээнд аймгийн төвд борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ 600.0 мянган төгрөг" гэж заасныг үндэслэн 12 сарын түрээсийн зардалд 7.2 сая төгрөг зарцуулжээ.

Түрээсийн хөнгөлөлт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 2 дугаар бүлгийн 2.3.4-д "ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ажлын байр түрээсэлж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдах шийдвэр гаргасан иргэдэд үзүүлнэ" гэж заасны дагуу "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээнд ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг үзүүлэхдээ тухайн зорилтот бүлгийн иргэний ажлын байрны түрээсийн төлбөрийн 40 хүртэл хувийг 6 сарын хугацаатай сар бүр нөхөн олгоно" гэж заасныг үндэслэн 3 иргэнд 0.5 сая төгрөгийн ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлжээ.

Нийтийг хамарсан ажил: "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 8.1-д "Нийтийг хамарсан ажлын зохион байгуулах төслийн хүрээнд байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийг эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчныг хамгаалах, ой цэвэрлэх, мод тарих, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх, усны нөөц сан байгуулах, засварлах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэж болно", 8.4-д "Нийтийг хамарсан ажилд хамрагдах иргэдийг сард ажлын 10 хүртэл хоногоор, өдөрт 8 хүртэл цагаар ажиллуулах ба ажилласан иргэдийн цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг ажилласан цагаар тооцож өдрөөр болон ажил хийгдэж дууссаны дараа олгоно" гэж заасны дагуу "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Нийтийг хамарсан ажлын жишиг хэмжээ: нэг цагийн хөлс 3.5 мянган төгрөг, нэг цагийн ажлын ХАБЭА-н

зардал 0.5 мянган төгрөг" гэж заасны дагуу 1769 иргэнийг нийтийг хамарсан ажилд хамруулж 153.8 сая төгрөгийн цалин олгож, ХАБЭА-н зардалд 9.8 сая төгрөг зарцуулжээ.



/хотын төв болон хорооллын зам талбайн цасыг цэвэрлэж байгаа нь/

Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах: “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 10.1-д " Иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд хамруулан сургаж, орлогоор дэмжинэ”, нэгдсэн удирдамжийн 2 дугаар бүлгийн 2.6.3-д "Арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хүнсний ногоо тариалахтай холбоотой үр бордоо, бага оврын багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, хашаа, хайс, хүлэмж барих, худаг гаргах, амралтын гэр, байр, барих зэрэг болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, бусад холбогдох үйл ажиллагааны зардалд зарцуулна" гэж заасны дагуу 72 иргэн хамруулан 23.7 сая төгрөг зарцуулжээ.

Дээрх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр						
Санхүүгийн дэмжлэг	68	201.0	68	201.0		0.0
Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	184	5.5	126	3.8		1.7
Борлуулалтын дэмжлэг		7.2		7.2		0.0
Түрээсийн хөнгөлөлт	23	11.0	3	0.5		10.6
Ажил олгогчийн урамшуулал	12	34.6	14	32.3		2.3
Нийтийг хамарсан ажил	180	164.1	1769	163.7		0.4
Хүнсний ногоо тариалах	70	35.0	72	23.7		11.3
Нийт		458.4		432.1		26.3



/Сийрэгжүүлэлт хийж, хор цацаж, бордоо хийж байгаа нь/

Санхүүгийн дэмжлэг:Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 2.2.1 “ эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох”, хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлийн 2 дугаар хуралдаанаар хэлэлцэж баталсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох төсөл сонгон шалгаруулах ажлын удирдамж зэргийг

үндэслэн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг 03 дугаар сараас эхлэн орон нутгийн иргэд, олон нийтэд мэдээлэл сурталчилгаа хийж 04 дүгээр сарын 19-өөс 05 дугаар сарын 03-ний өдрийг дуустал хувиараа хөдөлмөр эрхлэгч 35 ба түүнээс дээш насны хөдөлмөрийн насны иргэний зээл хүссэн материалыг Баян-Өндөр, Жаргалант сумын 24 баг дээр хүлээн авч Сумын амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн нийт 123 иргэний 369 сая төгрөг хүссэн материалыг хүлээн авчээ. Тус газрын гэрээ төслийн комиссын гишүүд, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан сумын мэргэжилтнүүд, Баян-өндөр, Жаргалант сумын багийн зохион байгуулагч, Эрдэнэт хамтын хөгжил ТББ-ын төлөөлөгч нар хамтран санхүүгийн дэмжлэг хүссэн иргэний /зээл/ материал болон нөхцөл байдалтай газар дээр нь танилцах 5 ажлын хэсэг хуваарилагдан 05 сарын 24-өөс 06 сарын 04-ийг дуустал газар дээр нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийж 68 иргэнд 201.0 сая төгрөгийн 100% эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Дэмжлэг авсан иргэд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой тус хөтөлбөрт хамрагдсан байна. Үүнд:

- Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл - 2 иргэн
- Хоол үйлдвэрлэл -4 иргэн
- Талх, нарийн боов үйлдвэрлэл - 3 иргэн
- Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл -1 иргэн
- Шахмал түлш, даацын блок үйлдвэрлэл - 3 иргэн
- Төмөр хийц, модон эдлэл үйлдвэрлэл – 9 иргэн
- Авто засвар, компьютер засвар - 6 иргэн
- Оёдол, сүлжмэлийн үйлдвэрлэл – 36 иргэн
- Явган замын бордюр үйлдвэрлэл - 1 иргэн
- Ногоо даршлах - 1 иргэн
- Хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэл - 1 иргэн
- 6 нэрийн дэлгүүр ажиллуулах - 1 иргэн байна.

Дэмжлэг авсан иргэдээс тогтмол үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй 40 иргэн байгаа ба авсан зээлээр 28 иргэн өөрт шаардлагатай тоног төхөөрөмж, материал худалдан авсан, 3 иргэн ажлын байр барьсан, 9 иргэн зөвхөн материал авсан байна.

Аудитын явцад 45 иргэнтэй уулзаж, эрхэлж буй үйл ажиллагаатай нь танилцахад 46 иргэн байнгын, 3 иргэн түр ажлын байртай болсон, Нийгмийн даатгал төлсөн мэдээлэлд аудит хийхэд 45 иргэн нийгмийн даатгал төлдөггүй, 6 иргэн байгууллагад ажиллаж нийгмийн даатгал төлдөг, 11 иргэн хувиараа төлсөн дүнтэй байна.

2017 оны эцсийн байдлаар 68 зээлдэгчээс 50.2 сая төгрөг төлөгдөхөөс 44.8 сая төгрөг буюу 89.2 хувь нь төлөгдсөн байгаагаас 47 зээлдэгч 35.4 сая төгрөгийг хугацаандаа төлж, иргэн Ц.Мөнхтуяа 0.6 сая төгрөг, иргэн Д.Энхтайван, Г.Энхээ, О.Мандах, А.Үржинмядаг, Ц.Саранчимэг, Б.Батболд нар тус бүр 0.5 сая төгрөг буюу 3.0 сая төгрөг, иргэн А.Пүрэв-Отгон 0.3 сая төгрөг, нэр бүхий 13 иргэн 2.0 сая төгрөг, нийт 6.0 сая төгрөг дутуу төлөгдсөн байна.

2017 онд ажил олгогчийн урамшуулалд нийт 66.8 сая төгрөг зарцуулсан байна. Үүнд:

2015 онд гэрээ байгуулсан компаниудаас ажилгүй 12 иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан 9 компанид 27.6 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан 2 компанид 4.6 сая төгрөг, нийт 14 иргэнийг ажлын байраар хангасан 11 компанид 32.3 сая төгрөгийн ажил олгогчийн урамшууллын өглөгтэй байсныг төлжээ.

/мянган төгрөг/

Д/д	Ажил олгогч байгууллагын нэр	Гэрээгээр ажлуулсан хүний тоо	Олгох урамшууллын хэмжээ
1	Бодгоно ХХК	1	2,304.0
2	Тэгшгунзан ХХК	1	2,304.0
3	Эржиэч ХХК	2	4,608.0
4	Их Нэмүүн Констракшин ХХК	1	2,304.0
5	Эмч Амин Эрдэнэ ХХК	1	2,304.0
6	Алтаннөмрөг ХХК	1	2,304.0
7	Сайханнамъяа ХХК	1	2,304.0
8	Орда Заан Хошуу ХХК	1	2,304.0
9	Монте Мебель ХХК	3	6,912.0
10	Шим дүүрэн сааль ХХК	1	2,304.0
11	Сарнайн хүрээлэн ХХК	1	2,304.0
Нийт		14	32,256.0

2016 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь ажилгүй 17 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн нийт ажилгүй 18 иргэнийг 12 сараас доошгүй хугацаанд ажлын байраар хангах нөхцөлтэйгөөр нэр бүхий 12 компанитай гэрээ байгуулжээ.

Үүнээс гэрээний үүргээ биелүүлэн 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар ханган, ажилгүй 14 иргэнийг ажиллуулсан 9 компанид 32.3 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан 1 компанид 2.3 сая төгрөг, нийт 10 компани 15 иргэнийг 12 сараас доошгүй хугацаанд ажлын байраар хангаж 34.6 сая төгрөгийн ажил олгогчийн урамшуулал олгожээ. Харин ажилгүй 4 иргэнийг 12 сарын турш ажиллуулаагүй аж ахуй нэгжүүдэд мөнгө олгоогүй байна.

/мянган төгрөг/

Д/д	Ажил олгогч байгууллагын нэр	Гэрээгээр ажлуулсан хүний тоо	Олгох урамшууллын хэмжээ
1	Ачуут сан ХХК	1	2,304.0
2	ЧЭС ХХК	2	4,608.0
3	Шидэт номин ХХК	1	2,304.0
4	Алтаннөмрөг ХХК	1	2,304.0
5	Мэнд Амар	1	2,304.0
6	Анса трейд ХХК	2	4,608.0
7	Гэгээн билиг сургууль	1	2,304.0

8	Капитрон банк ХХК	1	2,304.0
9	Бидний төгөл хоршоо	2	4,608.0
10	Эржиэч ХХК	3	6,912.0
Нийт		15	34,560.0

2017 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь ажилгүй 42 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн нийт ажилгүй 43 иргэнийг 12 сараас доошгүй хугацаанд ажлын байраар хангах нөхцөлтэйгөөр нэр бүхий 24 компанитай гэрээ байгуулан ажиллажээ.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд:

Гарааны бизнес эрхлэлтийн дэмжлэгт 20.0 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 8 хүн хамруулж 16.0 сая төгрөг, ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд 11 хүн хамруулж 5.3 сая төгрөг, аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтанд 92 хүн оролцуулж 2.8 сая төгрөг, борлуулалтын дэмжлэгт 7.2 сая төгрөг тус тус зарцуулахаар төсөвлөн, гүйцэтгэлээр гарааны бизнес эрхлэлтийн дэмжлэгт 49 хүн хамруулж 13.2 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 5 хүн хамруулж 15.0 сая төгрөг, аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтанд 90 хүн оролцуулж 2.7 сая төгрөг зарцуулсан байна.

Гарааны бизнес эрхлэлтийн дэмжлэг: "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн 4.1.3-т "Уг бүлгийн гишүүдэд гарааны бизнесийн таатай орчин бүрдүүлэх талаар сургалт, дараагийн шатанд аж ахуй эрхлэлт, бизнес загвар боловсруулах сэтгэлгээний сургалт зохион байгуулна", 4.1.5-д "төсөл шалгаруулж, шалгарсан нэг төсөлд 10.0 сая төгрөгийн гарааны дэмжлэгийг 24 сарын хугацаатайгаар олгоно" гэж заасны дагуу 2 иргэнд нийт 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн, 47 иргэнд 3.2 сая төгрөгийн зардлаар сургалт зохион байгуулсан байна.

Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт: Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн 6.10-д "Бизнес эхлэх, хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төлөвлөгөө, төсөл боловсруулах, гарааны бизнесийг хөгжүүлэх, хоршоо, нөхөрлөл, бүлэг байгуулж, үйл ажиллагаа эрхлэх, борлуулалтын сүлжээ, маркетингийн болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээрх сургалтын хөтөлбөрөөс сонгон аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдана" гэж заасны дагуу "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох 5 хоногийн сургалтын зардлын жишиг хэмжээ 30.0 мянган төгрөг" гэж заасныг үндэслэн 90 иргэнийг 2.7 сая төгрөгийн зардалтай сургалтанд хамруулсан байна.

Дээрх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр						
Гарааны бизнес эрхлэлтийн дэмжлэг		20.0	49	13.2		6.8
Санхүүгийн дэмжлэг	8	16.0	5	15.0	3	1.0
Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	92	2.8	90	2.7	2	0.1
Нийт		38.8		30.9	5	7.8

Санхүүгийн дэмжлэг: "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн 5.1-д "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг

төгсөгчийг хувиараа болон бүлгээр хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгох зорилгоор тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад нь зориулж, нэг төгсөгчид 3.0 сая төгрөг, бүлэгт 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгоно" гэж заасны дагуу Залуучуудын төсөл, бусад холбогдох материалыг 05 сарын 08-аас 09 сарын 12-ыг дуустал хүлээн авахаар зарлаж нийт 7 төсөл хүлээн авч төсөл шалгаруулах комиссын гишүүд, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан сумын мэргэжилтнүүд дэмжлэг хүссэн залуучуудын нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж 5 төслийг дэмжиж 15.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.

Дэмжлэг авсан иргэд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Үс засалтын үйлчилгээ –3 иргэн
- Төмөр хийц үйлдвэрлэл -1 иргэн
- Сүлжмэл үйлдвэрлэл – 1 иргэн
- Гахай үржүүлэг – 1 иргэн
- Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл -1 иргэн

Дэмжлэг авсан иргэдээс тогтмол үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй 2 иргэн байна. Энэхүү 2 иргэн авсан зээлийг өөрт шаардлагатай тоног төхөөрөмж, материал авахад зарцуулжээ.

Аудитын явцад 2 иргэнтэй уулзаж, эрхэлж буй үйл ажиллагаатай нь танилцахад 2 иргэн байнгын, 1 иргэн түр ажлын байртай болсон байна. Нийгмийн даатгал төлсөн мэдээлэлд аудит хийхэд 5 иргэн нийгмийн даатгал төлдөггүй, 2 иргэн байгууллагад ажиллаж нийгмийн даатгал төлсөн байна.

Зээлийн авлага 2017 оны эцсийн байдлаар 5 зээлдэгчээс 1.3 сая төгрөг төлөгдөхөөс 0.9 сая төгрөг буюу 70 хувь нь төлөгдсөн байгаа ба 3 зээлдэгч 0.8 сая төгрөгийг хугацаандаа төлж, иргэн Г.Аминжаргал 0.1 сая төгрөг, иргэн Г.Бат-Оргил 0.3 сая төгрөг, нийт 0.4 сая төгрөг дутуу төлсөн байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд:

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 8 өрхийг хамруулж 40.0 сая төгрөг, мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт зохион байгуулахад 39 хүнийг оролцуулж 4.9 сая төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөн гүйцэтгэлээр эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 9 малчин өрхийг хамруулж 40.0 сая төгрөг, аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт зохион байгуулах ажилд 25 малчныг хамруулж 2.5 сая төгрөг зарцуулжээ.

Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 2 дугаар бүлгийн 4.2.1-д "Аж ахуй эрхлэлтийн сургалт, мал маллагааны болон малын ашиг шим боловсруулах сургалт, туршлага солилцох уулзалтыг зөвхөн малжуулах арга хэмжээнд хамрагдаж байгаа малчин өрхөд зориулан зохион байгуулна" гэж заасны дагуу 25 малчныг сургалт, туршлага солилцох уулзалтанд хамруулж 2.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр						
Санхүүгийн дэмжлэг	8	40.0	9	40.0	1	0.0
Аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	39	4.9	25	2.5	14	2.4
Нийт		44.9		42.5	15	2.4

Санхүүгийн дэмжлэг: "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн 2.2.1-д "Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хөдөлмөрийн чадвартай, 15-39 насны 2-оос доошгүй гишүүнтэй, бог малд шилжүүлснээр 200 хүртэл толгой малтай малчин өрхийг хамруулна", 2.2.2-т "Арга хэмжээнд хамрагдах малчин өрх нь 150 хүртэл толгой малтай бол 5.0 сая төгрөг, 150-200 хүртэл толгой малтай бол 4.0 сая төгрөгийн мал худалдан авах арга хэмжээг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулна" гэж заасны дагуу Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан малчин өрхийн материалыг Баян-Өндөр, Жаргалант сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хөтөлбөрийн шаардлагад нийцсэн 15 малчин өрхийг дэмжиж ирүүлснийг ажлын хэсэг газар дээр нь үнэлгээ хийж малжуулах арга хэмжээнд Баян-Өндөр сумаас 5 малчин өрх, Жаргалант сумаас 4 малчин өрх нийт 9 малчин өрх хамрагдаж 40.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Нийгмийн даатгал төлсөн мэдээлэлд аудит хийхэд эдгээр 9 иргэн нийгмийн даатгал төлдөггүй байна.

Зээлийн авлага 2017 оны эцсийн байдлаар 9 зээлдэгчээс 10.0 сая төгрөг төлөгдөхөөс 6.6 сая төгрөг буюу 66.6 хувь нь төлөгдсөн байгаа ба 6 зээлдэгч 6.3 сая төгрөгийг хугацаандаа төлж, иргэн Б.Батнасан 0.8 сая төгрөг, иргэн Д.Эрдэнэбат, Б.Чингисбаатар нар тус бүр 1.3 сая төгрөг буюу 2.5 сая төгрөг, нийт 3.3 сая төгрөг дутуу төлсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд:

Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулахад 17 хүнийг хамруулж 4.9 сая төгрөг, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх сургалт зохион байгуулахад 25 хүнийг хамруулж 1.8 сая төгрөг, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээнд 12 хүнийг хамруулж, 1.7 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 13 хүнийг хамруулж 39.0 сая төгрөг, аж ахуй эрхлэх ур чадвар олгох сургалтанд 100 хүнийг хамруулж 3.0 сая төгрөг, борлуулалтын дэмжлэг үзүүлэхэд 7.2 сая төгрөг, ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөнд 5 хүнийг хамруулж 2.4 сая төгрөг, ажил олгогчийн урамшуулалд 2 хүнийг хамруулж 5.8 сая төгрөг, ажил олгогчид эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох ажилд 8 байгууллага хамруулж 24.0 сая төгрөг тус тус зарцуулахаар төсөвлөн, гүйцэтгэлээр мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулахад 12 хүнийг хамруулж 2.8 сая төгрөг, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх сургалт зохион байгуулахад 23 хүнийг хамруулж 1.6 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 14 хүн оролцуулж 39.0 сая төгрөг, аж ахуй эрхлэх ур чадвар олгох сургалтанд 14 хүнийг хамруулж 0.4 сая төгрөг, борлуулалтын дэмжлэг үзүүлэхэд 7.1 сая төгрөг, ажил олгогчийн урамшуулалд 1 хүн хамруулж 2.3 сая төгрөг зарцуулжээ.

Хөдөлмөрт бэлтгэх сургалт: "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 3.2.2-т "Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдэд сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, нийгэм, хамт олны дунд биеэ авч явах тухай сургалт, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хүнтэй харилцах, өөрийгөө ойлгуулах чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны анхан шатны зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагааны мэдлэг олгоно" гэж заасны дагуу "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын жишиг хэмжээ 70.0 мянган төгрөг" гэж заасныг үндэслэн 23 иргэнийг 1.6 сая төгрөгийн зардалтай сургалтанд хамруулсан байна.

Борлуулалтын дэмжлэг: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 2-р бүлгийн 5.4.1-т "Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ба "Борлуулалтын цэг"-т байршуулан борлуулах дэмжлэг үзүүлнэ" гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээнд аймгийн төвд борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ 600.0 мянган төгрөг" гэж заасныг үндэслэн 12 сарын түрээсийн зардалд 7.1 сая төгрөг зарцуулсан байна.

Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт: "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 3.7.2-т "Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн чадамж эзэмшүүлэх, үйлдвэрлэл дээрх ажлын байрны болон шавь сургалт зэрэг тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон төрөл хэлбэрийг сонгон зохион байгуулна" гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох 5 хоногийн сургалтын зардлын жишиг хэмжээ 30.0 мянган төгрөг" гэж заасныг үндэслэн 14 иргэнийг 0.4 сая төгрөгийн зардалтай сургалтанд хамруулжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн сургалт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 2 дугаар бүлгийн 5.5.4-т "Мэргэжлийн болон давтан сургалтад нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ"-ний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн сургалтын зардлын хэмжээг 30 хувиар нэмэгдүүлэн тооцох нь зөвхөн мэргэжлийн ур чадварын сургалтанд хамаарна" гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ"-г үндэслэн оёдолчин-4, тогооч-3, сүлжигч-1, /нэг суралцагчид ногдох сургалтын зардал 234.0 мянган төгрөг/ засал чимэглэлчин-1 /нэг суралцагчид ногдох сургалтын зардал 312.0 мянган төгрөг/ үсчин-3 /нэг суралцагчид ногдох сургалтын зардал 208.0 мянган төгрөг/ нийт 12 иргэнийг 2.8 сая төгрөгийн зардалтай сургалтанд хамруулжээ.

Ажил олгогчийн урамшуулал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр-ийн 4.2.1-д "Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тусгайлсан ажлын байраар хангасан тохиолдолд ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12

дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно" гэж заасны дагуу 1 ажил олгогчид 2.3 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Дээрх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр						
Хөдөлмөрт бэлтгэх сургалт	25	1.8	23	1.6	2	0.1
Санхүүгийн дэмжлэг	13	39.0	14	39.0	1	0.0
Борлуулалтын дэмжлэг		7.2		7.1		0.1
Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	100	3.0	14	0.4	86	2.6
Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	17	4.9	12	2.8	5	2.1
Ажил олгогчийн урамшуулал	2	5.8	1	2.3	1	3.5
Нийт		61.6		53.3	95	8.4

Санхүүгийн дэмжлэг: "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 3.1.3-т "Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх" гэж заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлийн 2 дугаар хуралдаанаар хэлэлцэж баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох төсөл сонгон шалгаруулах ажлын удирдамжийг үндэслэн Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг 03 дугаар сараас эхлэн орон нутгийн иргэд, олон нийтэд мэдээлэл сурталчилгаа хийж 04 дүгээр сарын 19-өөс 05 дугаар сарын 01-ний өдрийг дуустал Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын тогтоосон хүчин төгөлдөр шийдвэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн байдал нь ажил хөдөлмөр эрхлэхэд нь саад болохооргүй чадамжтай, өөрөө биечлэн хандсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хүүхэдтэй хувиараа хөдөлмөр эрхэлдэг эцэг, эхийн зээл хүссэн материалыг Баян-Өндөр, Жаргалант сумын 24 баг дээр хүлээн авч Сумын амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн нийт 52 иргэний 156.0 сая төгрөг хүссэн материалыг хүлээн авчээ.

Тус газрын гэрээ төслийн комиссын гишүүд, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан сумын мэргэжилтнүүд, Баян-өндөр, Жаргалант сумын багийн зохион байгуулагч, Эрдэнэт хамтын хөгжил ТББ-ын төлөөлөгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын төлөөлөл нар хамтран санхүүгийн дэмжлэг хүссэн иргэний /зээл/ материал болон нөхцөл байдалтай газар дээр нь танилцах 5 ажлын хэсэг хуваарилагдан 05 сарын 24-өөс 06 сарын 04-ийг дуустал ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй 8 иргэн, байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй хувиараа хөдөлмөр эрхлэгч 6 эцэг, эх нийт 14 иргэнд 39.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.

Дэмжлэг авсан иргэд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой тус хөтөлбөрт хамрагдсан байна. Үүнд:

- Алт, мөнгөний дархан -1 иргэн
- Модон эдлэл хийх -3 иргэн
- Малын тэжээл үйлдвэрлэх -1 иргэн
- Компьютер засвар -1 иргэн
- Фото зургийн студи ажиллуулах -1 иргэн
- Оёдол, сүлжмэлийн үйлдвэрлэл -7 иргэн

Дэмжлэг авсан иргэдээс тогтмол үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй 9 иргэн байгаа ба авсан зээлээр 2 иргэн ажлын байр барьсан, 6 иргэн багаж хэрэгсэл, 1 иргэн материал худалдан авчээ.

Аудитын явцад 9 иргэнтэй уулзаж, эрхэлж буй үйл ажиллагаатай нь танилцахад 9 иргэн байнгын, 3 иргэн түр ажлын байртай болсон Нийгмийн даатгал төлсөн мэдээлэлд аудит хийхэд 12 иргэн нийгмийн даатгал төлдөггүй, 1 иргэн байгууллагад ажиллаж нийгмийн даатгал төлдөг, 1 хувиараа төлсөн дүнтэй байна.

Зээлийн авлага 2017 оны эцсийн байдлаар зээлээс 14 зээлдэгчээс 5.4 сая төгрөг төлөгдөхөөс 5.0 сая төгрөг буюу 93.1 хувь нь төлөгдсөн байгаа ба 12 зээлдэгч 4.9 сая төгрөгийг хугацаандаа төлж, иргэн Б.Сабит, Г.Алтанцэцэг нар тус бүр 0.3 сая төгрөг нийт 0.6 сая төгрөг дутуу төлсөн байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 80 ахмадыг оролцуулж 22.4 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 4 ахмад иргэнийг хамруулж 10.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн, гүйцэтгэлээр ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 65 ахмадыг оролцуулж 18.2 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 4 ахмад иргэнийг хамруулж 10.0 сая төгрөг зарцуулжээ.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 2 дугаар бүлгийн 6.1.1-д "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон төрийн захиргааны салбарт зөвлөгөө үзүүлэх ахмад мэргэжилтэнг тухайн сум, дүүрэг, хорооны онцлогийг харгалзан аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс тодорхойлж хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 65 ахмадыг хамруулж Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн 4.3-д заасны дагуу "Нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлсний жишиг хэмжээ 3.5 мянган төгрөг"-өөр тооцон 18.2 сая төгрөгийн цалин олгосон байна.



Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрөөс санхүүгийн дэмжлэг авсан иргэний ажлын байр, үйлдвэрлэл явагдаж буй байдал

Санхүүгийн дэмжлэг: Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн 3.3-д "Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх" гэж заасны дагуу Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын баталсан "Ахмад мэргэжилтний зөвлөх

үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох төсөл сонгон шалгаруулах ажлын удирдамжийг үндэслэн, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан ахмадуудын төслийг 05 дугаар сарын 03-аас 05 дугаар сарын 12-ны өдрийг дуустал хүлээн авч Сумын амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн нийт 7 ахмадын материалыг хүлээн авч гэрээ төслийн комиссын гишүүд, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан сумын мэргэжилтнүүд, Баян-Өндөр, Жаргалант сумын багийн зохион байгуулагч, Эрдэнэт хамтын хөгжил ТББ-ын төлөөлөгч нар хамтран санхүүгийн дэмжлэг хүссэн иргэний /зээл/ материал болон нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж нөхцөл байдлын үнэлгээ хийж 4 иргэнд 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.

Дэмжлэг авсан иргэд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.Үүнд:

- Сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах-1 иргэн
- Оёдол-1 иргэн
- сүлжмэл үйлдвэрлэл- 1 иргэн
- гутал засварын үйлчилгээ-1 иргэн

Дэмжлэг авсан иргэдээс тогтмол үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй 1 иргэн байгаа ба авсан зээлээр материал худалдан авсан.

Аудитын явцад 1 иргэнтэй уулзаж, эрхэлж буй үйл ажиллагаатай нь танилцахад 1 иргэн байнгын ажлын байртай болсон. Нийгмийн даатгал төлсөн мэдээлэлд аудит хийхэд эдгээр 4 иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй, зээлийн авлага 2017 оны эцсийн байдлаар 4 зээлдэгчээс 2.5 сая төгрөг төлөгдөхөөс 2.6 сая төгрөг төлөгдсөн байна.

Дээрх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр						
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	80	22.4	65	18.2	15	4.2
Санхүүгийн дэмжлэг	4	10.0	4	10.0		0.0
Нийт		32.4		28.2	15	4.2

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх гэрээг 2 жилийн хугацаатайгаар 2017 оын 02 дугаар сарын 10-ны өдөр Голомт банкт байгуулан 20000.0 сая төгрөгийг Голомт банкинд дахь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эх үүсвэр дансанд байршуулсан байна.

Дээрх гэрээг үндэслэн Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Орхон аймаг дахь Голомт банкт 2017 оны 06 дугаар сарын 29-ны өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл хугацаатай 700.0 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Банк нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.1, 2.3, 2.4, 2.5-д заасны дагуу 22 хувиараа хөдөлмөр эрхлэгчид 141.4 сая төгрөг, 1 хоршоонд 10.0 сая төгрөг, 1 нөхөрлөлд 10.0 сая төгрөг, 5-н ХХК-д 95.0 сая төгрөгийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.10, 2.11-т заасны дагуу сарын 0.7 хувийн хүүтэй 256.4 сая төгрөгийн зээл олгосон байна.

3.2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн дүнд ажилгүйчүүдийн тоо буурч иргэдийн амьдрал дээшилж байгаа эсэх нь тодорхойгүй, судалгаа бүрэн хийгдээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг шинэчлэн “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”, “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нийт 6 хөтөлбөр баталсан. Үүнээс 5 хөтөлбөрийн арга хэмжээнд иргэдэд хүүгүй, барьцаагүй итгэлцэлийн үндсэн дээр зээл олгох юм. Уг арга хэмжээний талаарх мэдээллийг орон нутгийн телевизүүд, сонин сэтгүүлд нийтэлж иргэд, олон нийтэд сурталчилгаа мэдээллийн ажлыг хүргэж ажиллажээ.

2017 оны Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан болох LMIS программ-д 1229 идэвхтэй ажил хайгч иргэн бүртгэлтэй байгаагийн 705 нь буюу 57.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Нийт ажил хайгчдыг боловсролын түвшингээр авч үзвэл магистр болон дээд боловсролтой 35 хувь, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 5 хувь, техникийн болон мэргэжлийн боловсролтой 9 хувь, бүрэн дунд 46 хувь, суурь боловсролтой 4 хувийг эзэлж байна. 2016 оны 12 дугаар сарын байдлаар 1841 ажлын байрны захиалга хүлээн авсан бол энэ оны байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 1264 ажлын байрны захиалга хүлээн авчээ.

Ажил олгогч байгууллагуудыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилж үзэхэд үйлчилгээний болон боловсруулах үйлчилгээний салбар хамгийн их хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд энэ оны байдлаар сул чөлөөтэй ажлын байранд 1170 иргэн ажилд орсон байна. Нийт ажилд орсон иргэдийн 94.2 хувь нь буюу 1103 иргэн байнгын ажлын байртай болсон.

2017 онд нийт 1181 иргэн шинээр ажил хайгчаар бүртгүүлж, 1235 иргэний бүртгэл мэдээллийг идэвхжүүлсэн, идэвхгүй ажил хайгчийн төлөвт 2231 иргэн бүртгэлтэй байна.

Гадаадаас ажиллах хүчин авах чиглэлээр 14 ажил олгогч байгууллагаас 40 албан бичиг ирснийг судлан үзэж 39 албан бичгийн 232 иргэнийг ХХҮЕГ-т уламжлан, Орхон аймаг дахь “7 дахь өдрийн Адвентист сүм”-ээс ирсэн 1 албан бичгийг ХХҮЕГ-т уламжлахаас татгалзсан хариуг хүргүүлсэн ба аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэж байгаа нийт гадаадын иргэдийн жагсаалтыг 2 удаа албан тоотойр авахад 12 улсын 545 иргэн ажиллаж байна.

Хэдийгээр ХЭДС-аас иргэдийг ажилд зуучлах, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил олгогчийг дэмжих, сургалт зохион байгуулах, нийтийг хамарсан ажилд хамруулах зэргээр төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа боловч тогтвортой ажлын байр бий болж байгаа эсэх, сургалтанд хамрагдсан иргэд ажлын байраар хангагдаж байгаа эсэх, ажил олгогчдод дэмжлэг болж чадаж байгаа эсэх, эцсийн дүнд нийт ажилгүйчүүдийн тоо буурч иргэдийн амьдрал дээшилж байгаа эсэх нь тодорхойгүй судалгаа бүрэн хийгдээгүй байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан уу?

Бүлэг 4

Дотоодын хяналт хийхдээ шалгалтын зорилго, үр дүнг оновчтой тодорхойлоогүй, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр нь ямар үр дүнд хүрсэн, цаашид ямар арга хэмжээг авч ажиллах, үр дүнг тооцож, цаашдын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдээгүй байна.

4.1. Сангийн хөрөнгийн зарцуулалтанд дотоод хяналт хийж ажилласан ч хяналтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус байна.

Монгол улсын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.3 дахь заалтыг үндэслэн 2012 оны 01-р сарын 31-ний өдөр ХЭҮЗ-ийн 01 тоот тогтоол гарч ХЭСЗ-ийг аймаг, нийслэл, дүүрэгт байгуулах шийдвэр гаргаж салбар зөвлөлийн дүрмийг баталжээ.

Орхон аймгийн Засаг даргын 2017 оны 01-р сарын 16-ны өдрийн А/15 тоот захирамжаар аймгийн ХЭСЗ-ийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна.

ХЭАЗ-ийн дүрмийн 2.1-т “Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” 2.1.5-т “Тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлт дэмжих дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудал хэлэлцэж зөвлөмж гаргах, сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр хэлэлцэж дүгнэлт гаргах” гэж заасан боловч хэрэгжүүлээгүй байна.

Дотоод хяналтын нэгжээ Захиргаа хяналтын хэлтсийн даргаар ахлуулсан нийгмийн ажилтан, эдийн засагч, нягтлан бодох бүртгэл, хуулийн мэргэжилтэй ажилтнуудаас бүрдсэн баг томилон ажиллуулж хүн хүч, цаг хугацаа их шаардагдах ажлыг тус нэгжийн оролцоотой хэрэгжүүлэн ажиллажээ.

Төсөл хөтөлбөрийн шалгаруулалт, гэрээ хэлцэл хийхэд ил тод байдал, хяналтыг сайжруулах үүднээс газрын даргын тушаалаар томилогдсон комисс ажиллажээ.

Байгууллагын эрсдлийн төлөвлөгөөг гаргахдаа эрсдэлтэй ажил үйлчилгээг тодорхойлж эрсдлийг арилгах, бууруулах арга хэмжээг тодорхойлж хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын төлөвлөгөөнд оруулж графикийн дагуу төлөвлөгөөт хяналт хийгдэж байна. Байгууллагын удирдлагын шийдвэрээр болон хяналт хариуцсан мэргэжилтний гаргасан саналын үндсэн дээр тусгайлан баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт хийгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэнд 2017 оны 6-р сарын 30, 8-р сарын 31-ний байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хөтөлбөр тус бүрээр хийж дүнг үндэслэн биелэлт удааширч буй хөтөлбөрийн гүйцэтгэлийг сайжруулах талаар хариуцсан мэргэжилтнүүдэд зөвлөмж өгч ажиллажээ.

Мөн Хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд гэрээ байгуулан зохион байгуулж буй ажлуудад явцын болон гүйцэтгэлийн хяналтыг хийж гэрээг дүгнэн санхүүжилтийг олгож хэвшүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт олгохын өмнө холбогдох гэрээний үүргийн биелэлт болон анхан шатны баримтыг нягтлан шалгаж дотоод хяналтын мэргэжилтний дүгнэлт гаргаж санхүүжилтийг олгож байна. Энэ ажлын хүрээнд 2016 онд гэрээ байгуулсан 2 аж ахуйн нэгжид гэрээний үүргээ биелүүлээгүй, баримт материалын бүрдэлт хангалтгүй шалтгаанаар 9.2 сая төгрөгийн урамшууллыг олгохоос татгалзсан дүгнэлт гаргасан байна.

4.2. Сангийн үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө төвлөрүүлэн зарцуулж байгаа боловч түүний зарцуулалт, үр дүнг тооцож, цаашдын зорилтыг хэрэгжүүлэхэд дотоод хяналтын ажлыг чиглүүлээгүй байна.

“Хяналт шинжилгээ, үнэлгээний механизмыг боловсронгуй болгох” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд МУ-ын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу Дотоод хяналтын нэгжээ ЗХХ-ны даргаар ахлуулсан нийгмийн ажилтан, эдийн засагч, нягтлан бодох бүртгэл мэргэжилтэй ажилтнуудаар бүрдсэн баг томилон ажиллуулж, “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” боловсруулсан. Тус газар нь Дотоод хяналтын 2017 оны төлөвлөгөөг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзан боловсруулж хэрэгжүүлсэн байна.

Мөн Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл нь 2017 онд 3 удаа хурал хийсэн байна. Нэгдүгээр хуралдаанаар салбар зөвлөлийг шинэчлэн байгуулсан Засаг даргын 2017 он А/15 дугаар захирамж, хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн дүрэм, ХЭҮЗ-өөс батлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд, ХЭДС-ийн 2017 оны батлагдсан төсвийн хуваарь, “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийг санаачлан боловсруулсныг тус тус танилцуулж, хэлэлцсэн.

Хоёрдугаар хуралдаанаар хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн 2017 оны жилийн төлөвлөгөө, АБДХ, ХБИАБДХөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох төсөл сонгон шалгаруулах ажлын удирдамж батлах, бизнесийн чиглэл батлах, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг хүсэгчийн өрөгдлийн маягт баталсан байна.

Гуравдугаар хуралдаанаар “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалтай танилцах, 2017 оны төсвийн нэмэлт санхүүжилтийг тус тус хэлэлцсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дотоод аудитын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн нь ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтэнд 2017 оны 6-р сарын 30, 8-р сарын 31-ний байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хөтөлбөр тус бүрээр хийж дүнг үндэслэн биелэлт удааширч буй хөтөлбөрийн гүйцэтгэлийг сайжруулах, талаар хариуцсан мэргэжилтнүүдэд зөвлөмж өгч ажиллажээ.

Аудитын явцад хяналт шалгалтын ажил, хийсэн ажлын тайлантай танилцахад шалгалтын зорилго, үр дүнг оновчтой тодорхойлоогүй, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр нь ямар үр дүнд хүрсэн, цаашид ямар арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохистой эсэхийг тогтоогоогүй, зэргээс үндэслэн ХЭДС-д ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө төвлөрүүлэн зарцуулж байгаа боловч түүний зарцуулалт, үр дүнг тооцож, цаашдын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэл өгөх дотоод хяналт хангалттай хийгдээгүй байна.

Илрүүлсэн зөрчил: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Орхон аймагт 2017 онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн нийцлийн аудитаар 34.3 мянган төгрөгийн акт, 600.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүллээ. Мөн шинээр хийлгэсэн программ хангамжийг биет бус хөрөнгөөр бүртгэн авч байх, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг “эргэн төлөлт хийх хуваарь”-ийг зөрчин, дутуу төлсөн иргэдээс 10334.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах, хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах үүрэг нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтонд байгаа тул хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Орхон аймагт 2017 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

Дүгнэлт, зөвлөмж

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн дүнд ажилгүйчүүдийн тоо буурч, иргэдийн амьдрал хэрхэн дээшилж байгааг бодитой тодорхойлоогүй, дотоодын хяналт шалгалтыг хийхдээ үр дүнг тооцож цаашдын зорилго зорилтыг тодорхойлоход чиглүүлэх шаардлагатай байна.

Үндсэн дүгнэлтийг задлан харуулбал:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 5/02 дугаар тогтоолоор батлагдсан “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /Нэг өрх-нэг ажлын байр/ дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллажээ.

- ✓ Аймгаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийг хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль журманд заасны дагуу зохих байгууллагад хүргүүлж, зөвшөөрөл авч, эрх бүхий этгээдээр батлуулсан байна.
- ✓ Хөтөлбөрийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан байна.
- ✓ “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” хөтөлбөрийн хүрээнд 95 иргэн байнгын ажлын байраар, 24 иргэн түр ажлын байраар хангагдсан байна.
- ✓ Хэрэгжиж буй хөтөлбөрийн үйл ажиллагаанд тавих хяналт хийгдээгүй байна.

ХЭДТХ-нд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилахаар заасны дагуу орон нутгаас 100.0 сая төгрөг хуваарилсан байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг Монгол улсын Засгийн газрын тогтоолд заасны дагуу төлөвлөж төвлөрүүлээгүй нь 597.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжийг алдсан байна.

- ✓ Сангийн эх үүсвэрийг хууль, тогтоомжтой уялдуулан төлөвлөөгүй, орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилсан ч ХЭДС-ийн дансаар бус Хөдөлмөр, халамжийн

үйлчилгээний газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

- ✓ Сангийн орлогын бүрдүүлэлтийг бүрэн төвлөрүүлээгүй, төсөл хөтөлбөрийг ХЭДС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан хэдий ч, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн дүнд иргэдийн амьдрал дээшилж байгаа нь тодорхойгүй, судалгаа бүрэн хийгдээгүй байна.

- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулжээ.
- ✓ Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн дүнд ажилгүйчүүдийн тоо буурч иргэдийн амьдрал дээшилж байгаа эсэх нь тодорхой бус, эдгээрийн нотлох баримт, судалгаа хангалттай биш байна.

Дотоодын хяналт хийхдээ шалгалтын зорилго, үр дүнг оновчтой тодорхойлоогүй, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр нь ямар үр дүнд хүрсэн, цаашид ямар арга хэмжээг авч ажиллах, үр дүнг тооцож, цаашдын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдээгүй байна.

- ✓ Сангийн хөрөнгийн зарцуулалтанд дотоод хяналт хийж ажилласан ч хяналтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой бус байна.
- ✓ Сангийн үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө төвлөрүүлэн зарцуулж байгаа боловч түүний зарцуулалт, үр дүнг тооцож, цаашдын зорилтыг хэрэгжүүлэхэд дотоод хяналтын ажлыг чиглүүлээгүй байна.

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доорх албан тушаалтнуудад зөвлөж байна.

Орхон аймгийн Засаг даргын орлогч, Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн дарга А.Түвшинжаргал танаа:

- ХЭАЗ-ийн дүрмийн 2.1-д “Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” 2.1.5-д “Тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлт дэмжих дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудал хэлэлцэж зөвлөмж гаргах, сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр хэлэлцэж дүгнэлт гаргах”, гэсэн заалтыг хэрэгжүүлэн, сангийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлтийг ХЭДТ хууль, МУ-ын Засгийн газрын холбогдох тогтоолд заасны дагуу төлөвлөн зарцуулахад хяналт хэрэгжүүлэн, тайланг хэлэлцэж байхыг зөвлөж байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга Х.Эрдэнэбат, нягтлан бодогч О.Саранчимэг нарт:

- Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийн тооцоог нийгмийн даатгалын байгуулагатай нийлж, орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах.
- “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.
- ХЭДС-ийн хөрөнгийг иргэдийг аль болох тогтвортой ажлын байраар хангах, нийт ажилгүйчүүдийн тоог бууруулж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх чиглэлээр зарцуулан үр дүнг тооцож байх.
- Малжуулах хөтөлбөрийн үр дүнд малтай болсон иргэдийн малын тоог тооллогын “А” дансаар баталгаажуулах.
- Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйчүүдийн бүртгэлд хамрагдсан иргэдийг ажилд зуучилсан тохиолдолд ажил олгогчийг дэмжих хөтөлбөрт хамруулах, баримтын бүрдлийг хангах.

- Программ хангамжийг гэрээгээр гүйцэтгүүлсэн нөхцөлд биет бус хөрөнгөөр бүртгэж байх.
- ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтанд тавих дотоодын хяналтыг сайжруулан ажиллах.
- Төсөл хэрэгжүүлэгчдээс эргэн төлөх хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж хэвших, сангийн хөрөнгийн зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан ажиллахыг зөвлөж байна.

МЭДЭГДЭЛ:

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг мэдэгдье.

ТАНИЛЦСАН:

АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР

Д.ЦОГБАДРАХ

ГЭРЭЭТ АЖИЛТАН

З.ЭНХ-АМГАЛАН

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



**ОРХОН АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**


61000 Баян-Өндөр сум, Эрдэнэт, Баянбулаг баг
УБД-20/91, Утас: 70352353
E-mail:orkhon.hudulmur-halamj.gov.mn

2018.05.02 № 649
танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Орхон аймагт 2017 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт”-д хийсэн Нийцлийн аудитын тайлангийн төсөлд өгөх саналыг хүргүүлэв.

Хавсралт ...4... хуудастай.

ДАРГА  ХӨРДЭНЭБАТ

D/My documents/A-5

001419

НИЙЦЛИЙН АУДИТ / ОРА-2018-01-НА /-ЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД

ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Нэг. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017.01.27-ны өдрийн хурлын хоёрдугаар тогтоолоор баталсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.1.4-т “... орон нутгийн онцлогтой хөтөлбөр, төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг нь удирдан зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих” бүрэн эрхийн дагуу уг хөтөлбөрийг хэлэлцэн баталж 2.2.1-т заасан үүргийн дагуу аймгийн ИТХ-д санал хүргүүлснээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дах заалтыг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 5/02 дугаар тогтоолоор “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /нэг өрх-нэг ажлын байр/ аймгийн дэд хөтөлбөрийг баталсан. ХЭД тухай хуулийн 22.1.2, 23 дугаар зүйл, МУ-ын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Аймгийн Засаг даргын 2017.06.05-ны А/306, 2017.06.14-ний А/326 захирамжуудаар дээрх хөтөлбөрийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн нь тайлангийн төсөлд дурдсан “орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй” гэж үзэх үндэслэлгүй болно. Мөн “Сангийн орлогын бүрдүүлэлт хуулийн дагуу хийгдээгүй үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгөөр бүрэн санхүүжүүлсэн байна” гэсэн нь үндэслэлгүй бөгөөд 2017 онд ХЭДС болон аймаг, нийслэл, дүүргийн ХЭД дэд санд улсын төсвөөс хөрөнгө хуваарилаагүй бөгөөд ХЭД тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан бусад эх үүсвэрээр санхүүжсэн болно.

Хоёр. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-ыг баримтлан 25-аас дээш ажилтантай ААНБ-уудад нэхэмжлэл хүргүүлж зохих шаардлагын тавьж ажилласнаар тайлант онд 15.5 сая төгрөгийн ХЭДС-нд төвлөрүүлсэн. Тайлангийн төсөлд “...11 байгууллагын нэхэмжилбэл зохих 60.5 сая төгрөг байхад 30.3 сая.төгрөг нэхэмжилж 30.2 сая төгрөг дутуу нэхэмжилсэн байна.” гэсэн нь хөдөлмөрийн хуулийн 111.2 дах заалтын агуулгыг ойлгоогүйгээр тооцооллыг буруу хийсэн байна. Аж ахуй нэгж байгууллагад ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулбал зохих иргэний тооноос хасаж Засгийн газрын 2009.01.28-ны 26 дугаар тогтоолоор баталсан “ААНБ-аас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ”-г баримтлан мөнгөн дүнг нэхэмжилдэг болно. Манай байгууллага, ажилтан нь төлбөрийн нэхэмжлэх хүргүүлээд дутуу төлөгдсөн болон огт төлөгдөөгүй байгууллагуудад Хөдөлмөрийн хуулийн 141.1.5-ын дагуу арга хэмжээ авах эрхий бүхий байцаагчид мэдэгдэхээс өөрөөр хариуцлага тооцох боломжгүй байдаг.

11 байгууллагын төлбөр нэхэмжлэх дүнгийн тооцоолол

№	Байгууллагын нэр	Нийт ажилчдын тоо	Ажиллавал зохих ХБИ тоо	Ажиллаж байгаа ХБИ-ний тоо	Нэхэмжлэх мөнгөн дүн
1	Орхон АЗЗА ТӨХК	40	1	0	1-1152000
2	Шүүх	65	2	0	2-2304000 /2016 оны мөнгө/
3	ЭБЦТС ТӨХК	243	9	7	2-2304000 /2016 оны мөнгө/
4	Эрдэнэт ус ДТС ОНӨХК	334	13	9	4-5760000
5	Медипас ХХК	168	6	3	3-4320000
6	МУИС-ийн Эрдэнэт сургууль	112	4	2	2-2880000
7	НИК Орхон салбар ХХК	135	5	2	3-4320000

8	Номин тав трейд ХХК	78	3	1	2-2880000
9	Од дөл ХХК	35	1	0	1-1152000
10	Эрдсүлж ХХК	82	3	2	1-1440000
11	Эрдэнэт Фүүдс ХХК	78	3	2	1-1440000
Нийт дүн					29952000

Манай байгууллага холбогдох хууль, журмын дагуу олгогдсон эрх хэмжээний хүрээнд зохих төлбөрийг төвлөрүүлэн ажилласан бөгөөд тайлангийн төсөлд дурдагдсан “хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг төвлөрүүлээгүй”, “... 2017 онд 38 ААНБ-аас 429.7 сая төгрөг, 41 төсвийн байгууллагаас 182.9 сая төгрөг, нийт 612.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломжийг алдсан.” гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

Гурав. Хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэд 24 сарын дотор санхүүгийн дэмжлэгийг бүрэн барагдуулж дуусгах үүрэгтэй бөгөөд эргэн төлөлтийн хуваарийг зөрчсөн тохиолдолд хэрхэх тухай ямар нэг зохицуулалт хөтөлбөр, удирдамж, гэрээнд заагаагүй байна. Танай ирүүлсэн албан шаардлагын төсөлд тооцоологдсон хугацаа нь 5 сар буюу гэрээний нийт хугацааны 20% болж байгаа бөгөөд үлдсэн хугацаанд дэмжлэгийг бүрэн барагдуулах боломжтой юм.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг олгох” журмын 6.6 дах заалт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх болон санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны хэрэгжилтэд хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл болон аймаг дүүргийн салбар зөвлөл хяналт тавьж ажиллах үүргээ биелүүлж ажилласан бөгөөд санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн гэрээний дуусах хугацаа 2019.06.24-өөр байгаа тул албан шаардлагын төслийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж байна.

Дөрөв. “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан 25 ширхэг принтерийн хорыг зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан зөрчилд өгөх албан шаардлага, мөн хөтөлбөрийн хүрээнд эргүүл хамгаалалтын чиглэлээр түр ажлын байраар хангагдсан нэр бүхий 2 иргэнд илүү олгосон 34.3 мян төгрөгийн төлбөрийн актыг хүлээн зөвшөөрч байна.

ХХҮГ-ЫН ДАРГА

ХЭДС-ГИЙН

МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭРДЭНЭБАТ

О.САРАНЧИМЭГ



МОНГОЛ УЛС
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон,
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
И-мэйл: info@erdenet.mn

2018.05.02 № 2а/1374
танай 2018.04.27 -ны № 70 -Т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлд өгөх саналыг хүргүүлж байна.

Хавсралт ~~...~~ хуудастай.

ЗАСАГ ДАРГА
ОРЛОГ

А.ТҮВШИНЖАРГАЛ

D:/My documents/А-5. doc
0200000478

ОРХОН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС “ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР
ОРХОН АЙМАГТ 2017 ОНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ”-НД
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ТУСГАХ САНАЛ

2018.05.02

Эрдэнэт

Тус газраас хийсэн “Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Орхон аймагт 2017 онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт”-нд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад үндсэн дүгнэлтэд дараах саналуудыг тусгах саналтай байна. Үүнд:

1.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.7.1-д “Орон нутгийн төсвийн орлогын 0,3-иас доошгүй хувийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд хуваарилж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд зарцуулах” гэсэн заалт тусгагдсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.2, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 1.4, 2.2-д зааснаар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд хөрөнгө хуваарилуулах асуудлыг жил бүрийн төсөвт суулгуулах асуудлыг Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөс тасралтгүй хөөцөлдсөний үр дүнд 2014,2017,2018 оны төсөвт суулгуулж батлуулж ажилласан.

2016 онд Аймгийн ИТХ-ын ээлжит хуралдааны 2016 оны 12 дугаар сарын 02-ны №02 дугаар тогтоолоор, 2017 онд Аймгийн ИТХ-ын ээлжит хуралдааны 2017 оны 9/04 тогтоолоор тус тус батлагдсан “Хөрөнгө оруулалтын зардлын жагсаалт”-ад “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг төвлөрүүлж “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” орон нутгийн онцлогт нийцсэн хөтөлбөр боловсруулан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулах” гэсэн зүйл заалтаар төсөв батлагдсан.

Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.3-д заасан “Аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс дэд санд хуваарилсан хөрөнгийг тухайн орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зориулсан чиглэл, зорилтот арга хэмжээнд зарцуулна”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн зөвлөлийн үүргийн 2.2.2-д “Аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, холбогдох хөтөлбөрүүд, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг боловсруулах ажлыг санаачлан зохион байгуулах” гэсэн заалтуудтай уялдуулан 2017 онд батлагдсан төсвийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн аймаг, орон нутгийн бодлого шийдвэрийг хангах үүднээс батлагдсан 100,0 сая төгрөгийг “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай/нэг өрх-нэг ажлын байр/ хөтөлбөрийн хэрэгжилтэнд зарцуулж ХХҮГ-ын ХЭДСанд төвлөрүүлэн зарцуулж ажилласан.

Иймд Төрийн аудитын газраас өгч буй “Орон нутгаас төсөв хуваарилаагүй” гэсэн дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

2.Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай хөтөлбөрт нийт 1328 иргэн хамрагдсан. Судалгаанд хамрагдсан 2640 иргэнээс доорхи арга хэмжээнүүдэд 1328 иргэн хамрагдаж 1089 ажлын байр бий болсны 167 нь байнгын, 922 нь түр ажлын байр байна.

Энэ нь аймгийн хэмжээнд ажилгүйчүүдийн бүртгэлд бүртгэгдсэн хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үйл ажиллагаа, арга хэмжээнд хамрагдсан иргэдээс зөвхөн хөтөлбөрийн судалгаанд хамрагдсан иргэдийн тоо юм. Иймд дүгнэлтэд дурьдсан хөтөлбөрийн дэмжлэгийн хүрээнд 21 иргэн ажлын байраар, 7 иргэн түр ажлын байраар хангагдсан гэдэг тоо баримттай санал нийлэхгүй байна.

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо	Байнгын ажлын байр	Түр ажлын байр
Ажилд зуучилсан	39	39	3
Шинэ ажлын байр	80	80	
Нийтийг хамарсан ажилд	885		885
Эргүүл хамгааллын ажилд	15		15
Хүнсний ногоо тариалах арга хэмжээ	19		19
Санхүүгийн дэмжлэгт	26	51	
Мэргэжил олгох сургалт	42		
Хөдөлмөрт бэлтгэх сургалт	146		
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	76		
Нийт	1328	167	922

3.Хэрэгжиж буй хөтөлбөрийн үйл ажиллагааг 2 удаа Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн хурлаар, Удирдлагыг багийн хурлаар 2 удаа мөн сурталчлан таниулах болон, хэрэгжилтийн явц байдлын талаар дүгнэн хэлэлцсэн. Хөтөлбөр 2017 оны 08 дугаар сараас эхлэн 6 сар гаруйн хугацаанд хэрэгжсэн байх тул цаг хугацааны хувьд үйл ажиллагаанд хийгдэх хяналт хийх боломжгүй байсан тул цаашид энэ тал дээр анхаарч ажиллах болно.

4.Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөс зөвлөлийн батлагдсан эрх, үүргийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөрүүд болон дэмжих сангийн үйл ажиллагаа, тайланг салбар зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөний хүрээнд хэлэлцэж шаардлагатай тохиолдолд хэрэгжилттэй газар дээр нь очиж танилцах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэдэг ба цаашид зөвлөмжийн дагуу сайжруулж ажиллах нь зүйтэй юм байна гэж дүгнэж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг Аймгийн Засаг даргын орлогч, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга, ажил хариуцсан холбогдох хүмүүст танилцуулж санал тайлбарыг авлаа.

Орхон аймгийн Засаг даргын 2018 оны 05 сарын 02-ны өдрийн 2а/1374 тоот албан бичгээр ирсэн “2017 онд батлагдсан төсвийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн аймаг, орон нутгийн бодлого шийдвэрийг хангах үүднээс батлагдсан 100,0 сая төгрөгийг “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /нэг өрх-нэг ажлын байр/ хөтөлбөрийн хэрэгжилтэнд зарцуулж ХХҮГ-ын ХЭДСанд төвлөрүүлэн зарцуулж ажилласан” гэх санал, Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны 05 сарын 02-ны өдрийн 649 тоот албан бичгээр ирсэн “ХЭДТ хуулийн 22.1.2, 23 дугаар зүйл, МУ-ын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Аймгийн Засаг даргын 2017.06.05-ны А/306, 2017.06.14-ны А/326 захирамжуудаар дээрх хөтөлбөрийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн” гэсэн саналуудыг үндэслэн баримт материалыг дахин нягтлан шалгаж, тайлангийн төсөлд дурдсан “орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй” гэсэн дүгнэлтийг “орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилсан ч ХЭДС-ийн дансаар бус Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна” гэж залрууллаа.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны 05 сарын 02-ны өдрийн 649 тоот албан бичгээр ирсэн “2017 онд ХЭДС болон аймаг, нийслэл, дүүргийн ХЭД дэд санд улсын төсвөөс хөрөнгө хуваарилаагүй бөгөөд ХЭД тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан бусад эх үүсвэрээр санхүүжсэн болно” гэсэн саналыг үндэслэн баримт материалыг дахин шалгаж, тайлангийн төсөлд дурдсан “үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгөөр бүрэн санхүүжүүлсэн байна” гэсэн дүгнэлтийг “үйл ажиллагааг ХЭДС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна” гэж залруулан бичлээ.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны 05 сарын 02-ны өдрийн 649 тоот албан бичгээр ирсэн “хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг төвлөрүүлээгүй гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй” гэсэн саналыг хүлээн авч “хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй” гэж залрууллаа.

Орхон аймгийн Засаг даргын 2018 оны 05 сарын 02-ны өдрийн 2а/1374 тоот албан бичгээр ирсэн “дүгнэлтэд дурьдсан хөтөлбөрийн дэмжлэгийн хүрээнд 21 иргэн ажлын байраар, 7 иргэн түр ажлын байраар хангагдсан гэдэг тоо баримттай санал нийлэхгүй байна” гэсэн саналыг үндэслэн “хөтөлбөрийн дэмжлэгийн хүрээнд 21 иргэн ажлын байраар, 7 иргэн түр ажлын байраар хангагдсан байна” гэсэн дүгнэлтийг “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай дэд хөтөлбөрийн хүрээнд 95 иргэн байнгын ажлын байраар, 24 иргэн түр ажлын байраар хангагдсан байна” гэж залруулан бичлээ.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны 05 сарын 02-ны өдрийн 649 тоот албан бичгээр “хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан

иргэд 24 сарын дотор санхүүгийн дэмжлэгийг бүрэн барагдуулж дуусгах үүрэгтэй бөгөөд эргэн төлөлтийн хуваарийг зөрчсөн тохиолдолд хэрхэн тухай ямар нэг зохицуулалт хөтөлбөр, удирдамж, гэрээнд заагаагүй байна. Танай ирүүлсэн албан шаардлагын төсөлд тооцоологдсон хугацаа нь 5 сар буюу гэрээний нийт хугацааны 20% болж байгаа бөгөөд үлдсэн хугацаанд дэмжлэгийг бүрэн барагдуулах боломжтой юм. Санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөлтийн гэрээний хугацаа 2019.06.24-өөр байгаа тул албан шаардлагын төслийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж байна” гэсэн саналыг үндэслэн “эргэн төлөлт хийх хуваарийг зөрчин, дутуу төлсөн 10334.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлага”-ыг зөвлөмж болгон залрууллаа.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны 05 сарын 02-ны өдрийн 649 тоот албан бичгээр “11 байгууллагын нэхэмжилбэл зохих 60,5 сая төгрөг байхад 30,3 сая төгрөг нэхэмжилж 30,2 сая төгрөг дутуу нэхэмжилсэн байна гэсэн нь хөдөлмөрийн тухай хуулийн 111.2 дахь заалтын агуулгыг ойлгоогүйгээр тооцооллыг буруу хийсэн байна” гэсэн санал ирснийг залруулах боломжгүй гэж үзэж байна. Нийцлийн аудитыг хийх явцад Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хариуцсан мэргэжилтэнтэй уулзаж ярилцахад 25 байгууллагад нэхэмжлэх хүргүүлсэн гэсэн, тооцоо судалгааг яаж хийсэн тухай асуухад тодорхой тайлбар хийгээгүй тул ХХҮГ-ын мэргэжилтнээс шаардлагатай мэдээллийг өгөхийг хүссэний дагуу “үйл ажиллагаа явуулж байгаа 25, түүнээс дээш ажилтантай байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажиллаж байгаа судалгаа” 2017 оны 02 сарын 26 гэсэн огноотой баримт, “Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст бүртгэлтэй 25 дээш даатгуулагчтай аж ахуйн нэгж байгууллагын судалгаа” 2018 оны 3 сарын 22 гэсэн огноотой баримт, “хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 2017 онд нэхэмжлэх хүргүүлсэн байгууллагуудын жагсаалт” 2017 оны 11 сарын 16 гэсэн огноотой баримтыг өгсөн. Эдгээр баримтад тулгуурлан Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолоор баталсан “аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ”-г үндэслэн тооцооллыг зөв хийсэн. Гэтэл ХХҮГ нь аудитын тайланд санал авах явцад өөр тоо гарган ирж, хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ илэрхийлсэн байна.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2018 оны 05 сарын 02-ны өдрийн 649 тоот албан бичгээр “2017 онд 38 ААНБ-аас 429,7 сая төгрөг, 41 төсвийн байгууллагаас 182.9 сая төгрөг, нийт 612.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломжийг алдсан гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм” гэсэн санал ирсэн. Энэхүү саналд дурьдсан “2017 онд 612.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжтой байсан байна” гэсэн дүгнэлтийг нийт бүрдүүлэх боломжтой 612.6 сая төгрөгөөс төвлөрүүлсэн 15.5 сая төгрөгийг хасч “2017 онд 597.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжийг алдсан байна” гэж залрууллаа.

“Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Орхон аймагт 2017 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн” нийцлийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт

/ мянган төгрөгөөр/

Актын дугаар	Зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагч байгууллага	Төлбөр хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
			Албан тушаал	Нэр		
56/56	Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай дэд хөтөлбөрийн хүрээнд эргүүл хамгаалалтын чиглэлээр түр ажлын байр бий болгож нийт 17 иргэнд цалин олгохдоо М.Наранбаярт 13.8 мянган төгрөг, Т.Оюунбилэгт 20.5 мянган төгрөг, нийт 34.3 мянган төгрөг илүү олгосон байна.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Дарга, нягтлан бодогч	Х.Эрдэнэбат П.Наран	34.3	
63/63	Судалгаа хийх багт 25 ширхэг принтерийн хорыг 1025.0 мянган төгрөгөөр худалдан авах боломжтой байсныг 1625.0 мянган төгрөгөөр худалдан авч олгосон.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Дарга, нягтлан бодогч	Х.Эрдэнэбат П.Наран		600.0
	2017 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс авсан зээлээс 21 иргэн 6000.7 мянган төгрөг, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс авсан зээлээс 2 иргэн 375.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс авсан зээлээс 2 иргэн 625.0 мянган төгрөг, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс авсан зээлээс 3 иргэн 3334.0 мянган төгрөг, нийт 10334.7 мянган төгрөгний зээлийг гэрээний эргэн төлөгдөх хуваарийг зөрчин, дутуу төлсөн байна	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Дарга, нягтлан бодогч	Х.Эрдэнэбат О.Саранчимэг		10334.7
	Нийт дүн				34.3	10934.7